

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

БАЙГАЛ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР:

1. **Зорилго:** СҮХБААТАР–ЗАМЫН-ҮҮД төмөр замын шугамыг одоо байгаа гол замаас алсуур шинээр татагдсан дараах трассын дагуу байгал орчны төлөв байдлын судалгааг хийх.

2. **Хамрах хүрээ:**

2.1. Байгал орчинд нөлөөлөх байдлын төлөв байдлын судалгаа.

Шинээр төсөллөсөн дараах хэсгийн трассын дагуу байгал орчны төлөв байдлын судалгааг хийлгэх

- Баруунхараа – Аршаант – 152 км
- Оорцог-энгэр – Чойр – 10 км
- Чойр – Айраг – 38 км
- Сайншанд – Шаргын овоо – 241 км
- Нийт трассын урт – 461 км

2.2. Биологийн олон янз байдлын судалгаа

Мөлхөгч, мэрэгч, сээр нуруугүйтэн, шувуу, бусад хөхтөн: Дээрх трассын дагуух төмөр замын зурвас газарт

3. **Хийгдэх ажлууд, үе шатууд:**

3.1. Урьдчилсан судалгаа үнэлгээ:

- Хээрийн судалгааны шат:
- Төсөл хэрэгжих орчны суурь нөхцөл байдал болон байгал орчныг хамгаалах талаар авах арга хэмжээг тодорхойлох үүднээс ус, хөрс, агаар, ургамал, амьтан, түүх соёлын өвийн асуудлаар судалгаа хийх, дүгнэлт гаргах;
- Биологийн олон янз байдлын судалгаа - Зэрлэг амьтдын хээрийн ажиглалт судалгааны ажил
  - Хөхтөн амьтдын судалгаа
  - Шувуудын тооллого судалгаа
  - Мөлхөгчдийн судалгаа
  - Сээр нуруугүйтэн /артропод/ амьтдын судалгаа
- Ургамлын аймаг, ургамалжилтын судалгаа
  - Ургамлын бүлгэмдлийн зураг боловсруулах
  - Ургамлын зүйлийн бүрдэл, тархалт
  - Байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинжилгээний үр дүн: - Хөрсний: хими-физикийн, агро-химийн, хүнд металл - Усны: гүний усны чанар ба гүний түвшин

3.2. Байгал орчны төлөв байдлын тайлан:

- Төслийн техник, технологи, химийн болон биологийн бодис, түүхий эд, туслах материал, завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал, нийгмийн асуудлын талаар судалгаа хийх
- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн хэмжээ, тархалт, үр дагаврыг тогтоосон тооцоо, судалгаа, түүнийг арилгах арга хэмжээний зөвлөмж. Төслийн сөрөг нөлөөллийг бууруулах талаар авах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ.
- Байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгах;
- Төсөл хэрэгжих орчмын нутаг дэвсгэрт амьдардаг иргэдийн нийтийн хурлын санал, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн саналыг тайланд хавсаргах;
- Дунд хугацааны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулж тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник технологи, тоног төхөөрөмж, хөрөнгө зардал, боловсон хүчний тооцоог төлөвлөх;

**4. Тайлангийн агуулга:** Төслийн товч тодорхойлолт. Төслийн хүчин чадал, техник технологи, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн барилга байгууламж, ажилчдын хотхон, төслийн эцсийн бүтээгдэхүүн, түүхий эд туслах материал, хог хаягдал, үйлдвэрлэлийн туслах материал, ус хангамж;

- Төслийн байгаль орчинд нөлөөлөлх байдал, үнэлгээ Цаг уур, уур амьсгалын үзүүлэлтүүд, төслийн төлөвлөлтөнд авч үзэх уур амьсгалын хүчин зүйлс, байгалийн бүрэлдэхүүн /биологи, агаар, ус, геологийн тогтоц, газрын гадарга г.м/ тус бүрт нөлөөлөх байдлын үнэлгээ, төслийн талбайн цацрагийн түвшин.
- Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ
- Төслийн болзошгүй болон сөрөг нөлөөллүүд
- Төслийн эрсдлийн үнэлгээ, эрсдэлийн менежмент
- Биологийн олон янз байдлын судалгаа, судалгааны үр дүн.